



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын ЗҮҮНБАЯН ТОХИЖИЛТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/69/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа
		Цахим хаяг: smaudit97@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.28 № 16/253

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН "ТОХИЖИЛ
ЗҮҮНБАЯН" АЛБАНЫ ДАРГА
З.АМАРСАЙХАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын "Тохижилт-Зүүнбаян" албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын "Тохижилт-Зүүнбаян" албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 toot

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	148,533,424.83	167,892,614.83
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,714,867,630.98	1,567,384,760.87
	Нийт хөрөнгийн дүн	1,863,401,055.81	1,735,277,375.70
	Нийт өр төлбөрийн дүн	634,600.00	603,070.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,862,766,455.81	1,734,674,305.70
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,863,401,055.81	1,735,277,375.70
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	551,735,172.81	470,515,144.08
	Үйл ажиллагааны зардлын дүн	542,438,412.96	583,308,040.63
	Үйл ажиллагааны үр дүн	9,296,759.85	(112,792,896.55)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(16,843,679.27)	(29,835.00)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(7,546,919.42)	(112,822,731.55)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,870,313,375.23	1,847,497,037.25
	Тайлант оны үр дүн	(7,546,919.42)	(112,822,731.55)
	Эцсийн үлдэгдэл	1,862,766,455.81	1,734,674,305.70
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	425,896,601.21	432,377,430.08
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	421,059,001.21	431,827,530.08
	Үйл ажиллагааны ЦМГ	4,837,600.00	549,900.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(4,837,600.00)	(549,900.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	389,198,046.21	400,823,781.08
	Урсгал зардал	389,198,046.21	400,823,781.08
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	389,198,046.21	400,823,781.08
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	384,155,215.21	395,455,781.08
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	5,042,831	5,368,000.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засаг даргын Тамгын газар нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлага чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилладаг байна. Төрийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд иргэдийн амар тайван аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, ажилгүйдэл ядуурлын түвшинг бууруулан, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг цогцлоон төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг төгөлдөршүүлж, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд өссөн үндэсний тэргүүлэгч сум болох зорилго тавин ажиллаж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллага нь Морьтон-Эрдэнэ ХХК-аас Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 5 сая төгрөгийн дэмжлэгийг 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан хүлээн авч, Сайншанд сумын ЗҮҮНБАЯН ТОХИЖИЛТ-ийн даргын 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/22 тушаалаар тус хөрөнгийг зарцуулах тушаал гарган зарцуулсан байна. Тус дэмжлэгийн 3.2 сая төгрөгийг шатахууны зардалд, 0.6 сая төгрөгийг автомашины бэлэн байдлыг хангах зардалд, 0.3 сая төгрөгийг халдваргүйжүүлэлтийн зардалд, 0.2 сая төгрөгийг дархлаажуулалтын зардалд тус тус төлөвлөн зарцуулсан байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 330.9 сая төгрөгийн 23 орлогын гүйлгээ, 8.4 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 43 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш орлого бүхий гүйлгээнээс 1 гүйлгээг хугацаа хоцроосон, 5.0 сая төгрөгөөс дээш зарлага бүхий 1 гүйлгээг мэдээлээгүй, нийт 43 тушаал, шийдвэрээс 29 тушаалыг хугацаанд нь байршуулж, 14 тушаалыг огт байршуулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ковид-19 цар тахалтай холбоотой дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй хандив, тусламж хүлээн авч, зарцуулсан байх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 104.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 96.5 сая төгрөгийн алдааг залруулж, 8.0 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 0.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

1. Ерөнхий журналыг зардал тус бүрээр шүүж үзэхэд нийт 7.1 сая төгрөгийн 34 гүйлгээг буруу зардалд тусгасан байна. Тус алдааг аудитын явцад залруулав.
2. Ерөнхий журналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлын дансыг шүүж үзэхэд 81,120,991.09 төгрөгийн журналын бичилтийг буруу тооцооллын дансаар дамжуулан үүсгэсэн байна. Үүнийг 2006 оны Сангийн сайдын 388 дугаар тушаалын Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу аудитын явцад залруулав.

3. Бараа материалын дэлгэрэнгүй журналаас мал амьтад дансны орлого, зарлагыг бүрэн хамруулан шүүж, журналын бичилтийг шалгахад мал амьтдыг зарлагдахдаа 2.755.000 төгрөгийг 210901 дансруу хааж, орлогодохдоо 5.520.000 төгрөгийг 120018 дансруу хааж өгсөн байна. Энэ нь бодит орлого, зарлага биш бөгөөд тохируулах бичилт хийлгүй санхүүгийн тайланд тусгасныг аудитын явцад залруулав.

Зөвлөмж:

1. Санхүүгийн тайлангийн дахь бичиг хэргийн материалын дүн 0.4 сая төгрөгөөр, аж ахуйн материалын дүн 11.1 сая төгрөгөөр тооллогын бүртгэлээс зөрүүтэй бөгөөд 3 хөрөнгийн тооллого огт хийгдээгүй байна.
2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7 дансны 305.7 сая төгрөгийн 134 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Албан шаардлага:

1. Шалгадагч байгууллага нь 3 төрлийн 2.7 сая төгрөгийн авлага, 4 төрлийн 0.4 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгасан ба харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөгүй гэх өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг зөрчиж, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй Морьтон-Эрдэнэ ХХК-аас 5.0 төгрөгийн дэмжлэг хүлээн аван, зарцуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1 дэх заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Оргодолын Ганболдод 2020 оны 12 дугаар сараас эхлэн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгоогүй байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 57.2.4 дэх заалтыг зөрчиж, үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Тээврийн хэрэгслийн оношилгооны төлбөрөөс 0.006 сая төгрөгийн автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн хэрэгслийн албан татварыг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт мөн 2021 оны Сангийн сайдын 190 дүгээр тушаалыг тус тус зөрчиж, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
6. Шилэн дансанд мэдээлэх шаардлагатай 5.0 сая төгрөгөөс дээш дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй, хөрөнгө зарцуулах тухай 43 тушаал, шийдвэрээс 14 тушаалыг шилэн дансанд огт байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалт, 6.4.8 дахь заалтыг тус тус зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	11	104.9	3	96.5	-	-	6	8.0	2	0.4
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	11	104.9	3	96.5	-	-	6	8.0	2	0.4